

Арлингтон Нийтийн Сургуулиуд
504-р Хэсгийн доорх Эрх ба Журмын хэмжээнд авах хамгаалалт
504C

(Эцэг эх, асран хамгаалагч болон 18 болон түүнээс дээш насны сурагчдад)
Мэдэгдэл

Төлөвлөлтийн явцад дараах тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч болон 18 ба түүнээс дээш насны сурагчдад 504-р Хэсгийн доорх эрхийг нь олгоно:

- Өргөдөл хүлээн авах;
- Хамрагдах эрхийг тогтоох;
- 504-р Хэсгийн Төлөвлөгөөг боловсруулах;
- Өргөдөл гаргах, хуваарилах, 504-р Хэсгийн Төлөвлөгөөнд томоох өөрчлөлт оруулахын өмнө.

Арлингтон Нийтийн Сургуулиуд дээр эцэг эх/асран хамгаалагч болон 18 болон түүнээс дээш настай сурагчид дараах эрхтэй байна: • хамрагдах эрх болон/эсвэл төлөвлөгөө, хөтөлбөртэй холбоотой санал болгож буй арга хэмжээний талаар мэдэгдэл хүлээн авах;

- хүүхдийг анхлан шалгах болон анхлан хуваарилахад зөвшөөрөл өгөх;
 - төрөл бүрийн эх сурвалжаас авсан мэдээлэлд тулгуурласан шалгалт өгөх;
 - тухайн хүүхдийн талаар болоод ямар хөгжлийн бэрхшээлтэй болох, мөн хамрагдах эрхийг тогтоох шалгалтын журмын талаар мэддэг зөвлөлтэй байх;
- хүүхдийнхээ талаарх холбогдох бүх бүртгэлтэй танилцан шүүх, мэдээлэл задруулах зөвшөөрөл өгөх;
- үе үе дахин шалгалт өгөх, мөн хуваарилалтад томоохон өөрчлөлт оруулах өмнө дахин шалгалт өгөх;
- хамгийн бага хязгаарлалттай орчинд хүүхдээ суралцуулах;
- 504-р Хэсгийн Нийцлийн Зөвлөлийн шийдвэрийг давж заалдах;
- маргаантай асуудал дээр төвийг сахисан хурал хийлгэх хүсэлт гарган зөвлөлөөр төлөөлүүлэх;
- төвийг сахисан хурлын даргын шийдвэрийг шүүхэд давж заалдах;
- Иргэний Эрхийн Албанд гомдол гаргах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гаргасан зан араншин нь сахилгын арга хэмжээ авах нөхцөлд хүргэж хуваарилалтад өөрчлөлт оруулсан бол үүний дараа тухайн гаргасан зан араншин нь хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй эсэхийг тогтоолцох.

Эцэг эх/асран хамгаалагчдад хүүхдийнх нь 504-р Хэсгийн үйл явцтай холбоотой бүх хурлуудын талаар мэдэгдэн үйл явцын үе шат бүрд оролцохыг уриална. Эцэг эх/асран хамгаалагч нь дээрх хурлуудад нэмэлт хүмүүсийг оролцуулах эрхтэй байна. Хурлын бүх протоколын хуулбар болон шалгалтын дүнгийн бүх хуулбаруудыг эцэг эх/асран хамгаалагчдад үнэ төлбөргүй олгоно.

Зөвшөөрөл

Аливаа сурагч 504-р Хэсгийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй сурагч эсэхийг хэлэлцэж үзэхийн өмнө эцэг эх/асран хамгаалагчдад мэдэгдэх ёстой. Уг мэдэгдэлд эдгээр эрхийн хуулбаруудыг оруулсан байна. Сурагчаас хувийн шалгалт авахын өмнө эцэг эхээс бичгээр зөвшөөрөл авах ёстой. Хэрэв дахин шалгалт авч байгаа бол эцэг эхийн зөвшөөрлийг мөн авна. Сургуулийн зүгээс үйлчилгээг ерөнхий боловсролын хүрээнд үзүүлэхийн тулд эцэг эхийн оролцоог дэмжинэ.

Бүртгэл

Эцэг эх/асран хамгаалагч нь өөрийн зардлаар бүртгэлийн бүх хуулбарыг авах болон танилцах эрхтэй байна. 504-р Хэсгийн хурлаас гарах аливаа мэдээлэл нь нууц байх ба эцэг

эх, асран хамгаалагч болон 18-аас дээш насны сурагчийн бичгээр олгосон зөвшөөрлийн дагуу задруулна. Бүртгэлүүдийг сурагчийн боловсролын бүртгэлд хадгална.

March 2020

Эцэг эх/асран хамгаалагч нь бүртгэл дэх мэдээлэл буруу ташаа, эсвэл хүүхдийн хувийн нууцын эрхийг зөрчиж байна гэж үзвэл өөрчлөлт оруулуулах хүсэлт гаргах эрхтэй байна. Сургуулийн дүүргийн захиргаа нь эцэг эхийн хүсэлт гаргаснаас хойш зохих хугацаанд өөрчлөлт оруулж болох эсэхийг шийднэ. Хэрэв сургуулийн дүүргийн захиргаа өөрчлөлт оруулахгүй гэж үзвэл эцэг эх/асран хамгаалагч нь тухайн шийдвэр дээр хурал хийлгэх хүсэлт гаргах эрхтэй байна. Тухайн хурлыг хүсэлт гаргаснаас хойш зохих хугацаанд хуралдуулах ба хурлыг Арлингтон Нийтийн Сургуулиудын албан хаагч зэрэг хурлын шийдвэрт шууд ашиг сонирхол байхгүй ямар ч хүн хуралдуулж болно.

Асуулт ба Маргаан шийдвэрлэх

Хэрэв 504-р Хэсгийн Төлөвлөгөөний хэрэгцээ шаардлага, шалгалт, хуваарилалт, заалттай холбоотой ямар нэг асуулт, маргаан байвал дараах туслалцааг үзүүлнэ:

1-р Алхам: Сургуулийн түвшинд

Сургуулийн захирал эсвэл үүрэг гүйцэтгэгч (үүрэг гүйцэтгэгч нь ихэвчлэн Бага ангийн хувьд Захирлын туслах, дунд ангийн хувьд Зөвлөх үйлчилгээний Дарга байна). Сургуультай холбоо барих тусгай мэдээллийг дараах хаягнаас авна уу <http://www.apsva.us/contact-or-call-703-228-6000>

2-р Алхам: Дүүргийн түвшинд 1

504-р Хэсгийн Зохион байгуулагч
Женнифер Ламбдин | jennifer.lambdin@apsva.us | 703-228-2800 X 98051

504-р Хэсгийн Зохион байгуулагч
Карен Рейх | karen.reich@apsva.us | 703-228-2800 X 97636

3-р Алхам: Дүүргийн түвшинд 2

504-р Хэсгийн Нийцлийн Зохион байгуулагч
Доктор Лора Ньютон
Сурагчийн Үйлчилгээний Дарга
laura.newton@apsva.us
703-228-6061

Эцэг эх/асран хамгаалагч нь 504-р Хэсгийн Нийцлийн Зөвлөлийн шийдвэрийг хэзээ ч хамаагүй давж заалдах, Иргэний Эрхийн Албанд гомдол гаргах, төвийн сахисан хурал хуралдуулах хүсэлт гаргах эрхтэй байна.

504-р Хэсгийн Нийцлийн Зөвлөл

504-р Хэсгийн Нийцлийн Зөвлөл нь маргаан шийдвэрлэдэг баг юм. Энэ нь тусгай боловсролын асуудал, маргааныг шийддэг зөвлөлөөс тусдаа юм. Сургуулийн түвшинд 504-т хамрагдахыг шийддэг зөвлөлөөс мөн тусдаа юм. Эцэг эх/асран хамгаалагч нь Иргэний Эрхийн Албад хандах эсвэл төвийн сахисан хурал хуралдуулах хүсэлт гаргахын өмнө энэ зөвлөлд хандах шаардлагагүй.

504-р Хэсгийн Нийцлийн Зөвлөл нь 504-р Хэсгийн Нийцлийн Ажилтан эсвэл үүрэг гүйцэтгэгчийг оролцуулаад гурван гишүүнээс бүрдэнэ. Хамрагдах эрхийг тогтооход тухайн сурагчийн талаар мэддэг нэг ажилтан, шалгалтын дүн болон бусад шалгалттай холбоотой мэдээллийг мэддэг нэг хүн болон хамрагдалтын асуудалд хамаатай гэж үзсэн бусад хүмүүс зөвлөлд орж ажиллана.

Эцэг эх/асран хамгаалагч нь 504-р Хэсгийн Нийцлийн Зөвлөлийн хуралд уригдаж оролцох эрхтэй байна (504В маягт, “Бусад” хурал). Эцэг эх/асран хамгаалагч эсвэл АНС-н хүсэлтээр нэмэлт хүн хуралд оролцож болно.

March 2020

Талууд хурал болохоос өмнө оролцогчдын нэр болон үүргийг мэдээлэх үүрэг хүлээнэ. Хурал дээр Нийцлийн Зөвлөл нь холбогдох талуудын бүх асуудлыг сонсож сургууль эсвэл эцэг эх/асран хамгаалагчийн олгосон баримт бичгийг хүлээн авна. Зөвлөл нь шийдвэр гаргасны дараа дүнг ажлын 10 хоногийн дотор хэрэгжүүлүүлэхээр эцэг эх/асран хамгаалагч болон сургуульд дамжуулна (504J Маягт)

Төвийг сахисан хурал

Төвийг сахисан хурлаар зохих журмын хүрээнд хэрэгцээ шаардлага, шалгалт, хуваарилалт, заалттай холбоотой зөрчлийг шийдвэрлэнэ. Эцэг эх/асран хамгаалагч нь хуралд оролцон зөвлөхөөр төлөөлүүлэх эрхтэй байна. Хурал хуралдуулах хүсэлтийг дараах этгээдэд гаргана:

Dr. Laura Newton
Director of Student Services
Section 504 Compliance Officer
Arlington Public Schools
2110 Washington Blvd., Arlington, VA 22204
703-228-6061
laura.newton@apsva.us

504-р Хэсгийн Нийцлийн Зөвлөлийг эцэг эх/асран хамгаалагчийн зохих хурлыг хуралдуулах хүсэлт гаргах эрхийг түтгэлзүүлэх, саатуулахад ашиглахгүй.

Иргэний Эрхийн Алба

Эцэг эх/асран хамгаалагч нь Иргэний Эрхийн Албанд (бүс нутгийн алба) гомдол гаргах эрхтэй байх ба тус алба нь техникийн дэмжлэг үзүүлэхээс гадна нийцэл, гомдолд хяналт шалгалт хийдэг. Ялгаварлан гадуурхах явдал гаргасан гэж үзвэл 180 хоногийн дотор гомдол гаргана. Иргэний Эрхийн Алба нь хөгжлийн бэрхшээлд үндэслэн ялгавартай харьцах, сургуулийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх, дарамтлах, үнэ төлбөргүй зохих нийтийн боловсролыг олгохгүй байх зэрэг ялгаварлан гадуурхах үйлдлийг шалгадаг. Хэрэгцээ шаардлага, шалгалт, хуваарилалттай холбоотой шийдвэрийг хянан шалгахдаа дүрэм журмыг мөрдлөг болгодог. Хэрэв сургуулийн салбар хэлтэс Иргэний Эрхийн Албаны дүрмэнд шаардсан (АНС-н журманд тусгасан) журмыг мөрдсөн бол Иргэний Эрхийн Алба нь тухайн салбар хэлтсийн шийдвэрийг шүүмжлэхгүй.

Хаяг:

Office for Civil Rights, District of Columbia Office
U.S. Department of Education
400 Maryland Ave., SW
Washington, D.C. 20202-1475
(202) 453-6020; FAX (202) 453-6021; TDD 877-521-2172
ocr.dc@ed.gov, www.ed.gov/ocr

March 2020